

ЗҮҮН ХОЙД АЗИЙН АЮУЛГҮЙ БАЙДАЛ БА ХҮЧНИЙ ТЭНЦВЭРИЙН АСУУДАЛ

Д.Бүдсүрэн*

Ази, Номхон далайн бүс нутгийн дэд бүс Зүүн хойд Азийн нутгийн бүс улс төр, эдийн засгийн орчин, аюулгүй байдал, тус бүс нутаг дахь хүчний тэнцвэрт харьцаа, хүчний тэнцвэрийн тогтолцооны тухай товч дурдаж, үүндээ дүгнэлт хийхийг хичээлээ. Үүнд:

- Хүчний тэнцвэрийн тухай ухагдахуун;
- Хүчний тэнцвэрийн онол;
- ЗХА-ийн улс төрийн хүчний тэнцвэрийн асуудал;
- Хүчний тэнцвэрийн тухай ухагдахуун.

Орчин үед олон улсын харилцаанд аюулгүй байдалтай холбогдон хүчний тэнцвэрийн асуудал нэлээд чухалд тооцогдох болсон. Хүчний тэнцвэрийн асуудал нь ЗХА-ийн бүс нутгийн хувьд шинэлэг ойлголт гэж үзэж болно. Бүс нутгийн орнуудын хооронд улс төр, эдийн засаг, цэрэг стратеги, түүгээр ч үл барам үзэл суртлын хувьд зөрчил мөргөлдөөн гарахад уг асуудлыг их гүрнүүдийн оролцоотойгоор тэнцвэржүүлэн шийдвэрлэх хэрэг гардаг. Үүнээс хүчний тэнцвэр гэсэн ухагдахуун аливаа асуудлыг зохицуулах, тэнцвэржүүлэн шийдвэрлэх үүрэгтэйгээр гарч ирж байна. Хүчний тэнцвэрийг бүс нутгийн хувьд авч үзвэл тухайн бүс нутаг дахь их гүрнүүдийн үндэсний ашиг сонирхол, геостратегийн бодлого нь аюулгүй байдал, эдийн засаг, улс төр, цэрэг армийн бодлогоор илрэн гарч буй үйл явц мөн. Хүчний тэнцвэр өөрөө үндэсний эрх ашиг, батлан хамгаалах, зэр зэвсэг, цэрэг, стратегитай холбогдох өргөн ойлголт мөн. Хүчний тэнцвэрийн тухай ойлголт хэдэн зуун жилийн улбаатай боловч эдүгээ олон улсын харилцааны хувьсал өөрчлөлтийг дагаад шинэ агуулга, хандлагыг илэрхийлж байна.

Хүчний тэнцвэрийн онол

* МУИС-ийн ОУХС-ийн багш, докторант

Хүчний тэнцвэрийн зарчмыг анх XV зууны хоёрдугаар хагаст Италийн улс төрийн харилцааг тодорхойлох зорилгоор хэрэглэж байжээ. Тэр үед Апенины хойг дээр хүчирхэг дөрвөн гүрэн оршиж байв. Энэ нь Венецийн түрэмгийллийг хазаарлан зогсоож, тусгаар тогтнолоо хамгаалахын тулд Флоренц, Милан, Неаполь нь хоорондоо холбоо тогтоож хойг дээр шаардлагатай хүчний тэнцвэрийг бий болгосон байна. XVI зууны дунд үед Венецийн дипломатууд Испанийн Габсбург, Францийн Валуа нарын тасралтгүй тэмцлийг 2 эзэнт гүрний хоорондох хүчний тэнцвэрийг тогтоох зорилготойгоор хүчний тэнцвэрийн бодлогыг тодорхойлж байв.¹

XVI зууны хоёрдугаар хагасаас эхлэн тэнцвэрийн тухай ухагдахуун Европын нөхцөл байдлыг бүхэлд нь зохицуулын тулд бага багаар хэрэглэгдэх болжээ. XVII зууны эхний хагаст Францын гугенотуудын манлайлагчдын нэг герцог Роанский тэр үеийн олон улсын харилцааны нийтлэг үзлийг илэрхийлсэн. Тэрбээр, Франц, Испани хоёр олон улсын улс төрд 2 туйлын байр суурь эзэлдэг төдийгүй тэдгээрийн хоорондын хүчний тэнцвэр нь бусад улс орнуудын улс төрийн бодлогыг удирдан чиглүүлэх ёстой гэжээ.

XVII зууны хоёрдугаар хагаст Европын улс төрийн байдал XIV-р Людовикийн түрэмгийлэн эзлэх бодлогоор тодорхойлогдож байсан. Габсбургийн гэр бүлийн нөлөө, хүч суларч Европ дахь хүчний тэнцвэрт Франц гол аюул занал учруулж байна гэж үзэх болсон. Үүнийг анх Австрийн улс төрийн зүтгэлтэн Ф.П.Барон Лизола өөрийн өгүүлэлдээ 1667 онд бичиж, тэр нь франц, герман, англи хэл дээр орчуулагдан гарсан. Түүний өгүүллийн гол зорилго нь Английг Австритай холбоотон болгож, протестант хаадыг хамтран Францын хаант засгийн төлөвлөгөөг нураах бодлого явуулахаас сэрэмжлэхэд оршиж байсан. Лизола хэлэхдээ, Францын хаан цогц хаант засаг байгуулахыг оролдсоноос Европын эрх чөлөө, шашин шүтлэг, худалдаа наймаанд аюул занал учруулж байна.

1700 онд хүчний тэнцвэрийн онол түгэн дэлгэрснийг олон нийт хүлээн зөвшөөрсөн төдийгүй үүнийг Европын эрх чөлөөтэй холбон үзэж байв. Тэр ч байтугай XVIII зууны “Европ” гэдэг ойлголтыг хүчний тэнцвэрийн онолтой нягт холбон үздэг байв. Мөн энэ үзэлтэй бусад орнуудын эрх чөлөө, протестант шашны чөлөөт байдал, английн чөлөөт худалдаа зэрэг нь холбогдож байлаа. 1756

¹ К.С.Гаджиев. “Введение в геополитику”. Москва. 1998 он. 124-р тал

онд “дипломат хувьсгал” гарснаас андгайт дайсан Габсбург, Бурбонууд холбоотон болж, Пруссийг Их Британи дэмжиж эхэлсэн. Үүний үр дүнд маш нарийн систем бий болж “пентархи буюу 5-ын засаглал” гэж нэрлэсэн. Энд Их Британи, Франц, Австри, Прусс, Орос зэрэг орнууд нэгдсэн байна.

Францын шашны зүтгэлтэн, XVII-XVIII зууны эхэн үеийн улс төрийн зөвлөх асан Ф.Фенелон нь хүчний тэнцвэрийн мөн чанарыг анх ойлгож хэрэгжүүлсэн хүн гэж ойлгож болно. Хүчний тэнцвэр нь байнгын элемент биш бөгөөд харин байнга өөрчлөгдөн хувирч, давтагдан хөдөлгөөнд оршиж байдаг шинж чанартай. Үүнийг XIX зууны Европын орнуудын харилцаа гэрчилж байна. Хүчний тэнцвэрийн хөдөлгөөнтэй байнгын шинжийг 1815 оны Венийн Конгрессын үед хийсэн гэрээ, хэлэлцээрүүд гэрчилнэ. Тэр жил Оросын хаан, Австрийн эзлэн түрэмгийлэгч, Пруссийн хаан нар Наполеоны дайны дараа холбоо байгуулж, энэ нь христосын туйлын бодол дээр тулгуурласан Европын ард түмнүүдийн хооронд энх тайван, ах дүүгийн найрамдалт харилцаа тогтоож, хууль ёсны эздийн удирдлага дор оршин амьдрахыг уриалсан. Шашны талаас бол үнэн алдартны Орос, католик Австри, протестант Прусси гурвын экуменик холбоо байлаа. Энэ нь үндэстний язгуур чанараас давсан холбоо болж, уг холбоо нь улс орны дотоодын эрх мэдэл, шашин шүтлэгийн асуудалд үл оролцохоос гадна аль нэг нь гадна, дотны түрэмгийлэлд өртвөл холбоотны дагуу хамтран тэмцэх ёстой байв. Энэ үед Орос барууны орнуудтай эрх тэгш харилцаж байв.

Наполеоны дайны дараа Европын их гүрнүүд, Европын аюулгүй байдлыг хангах үүднээс нэгдсэн систем байгуулахыг эрмэлзэн, арга зам хайж эхэлсэн. Венийн хэлэлцээрүүд маш хүнд нөхцөлд явагдсан ч үр дүнд нь Европын их гүрнүүдийн “концерт” бий болсон юм. Үүний гол ач холбогдол нь хүчний тэнцвэрийг хадгалахын тулд газар нутгийг дахин хувааж, ихэнх орнуудын хил хязгаарыг өөрчилсөнд оршиж байв. Шинэ системийн гол зарчим нь шинэ газар нутгийн хүчний тэнцвэрийг хүндэлж, зөрчил гарсан тохиолдолд харилцан хэлэлцэж шийдвэр гаргах явдал байлаа. Энэ нь их гүрнүүдийн дарангуйллыг Европын олон улсын харилцаанд хуульчилсан явдал байв. Энэ зохицуулалт 40 жилийн туршид мөрдөгдсөн. Их гүрнүүд тухайн үед жижиг орнуудыг хатуу хянаж, хувь заяаг нь атгаж байв. Гэвч Балканы хойг дээр байнга зөрчил мөргөлдөөн, үндсэрхэг хөдөлгөөн газар авч, буурайчууд өөрийн улсыг

байгуулахын төлөө тэмцэж эхэлсэн гэж хэлж болно. Австри-Унгар, Османы эзэнт гүрэн суларч эдгээр хөдөлгөөн улам хүчээ авав. Гэвч Вестфалийн системийг өөрчилж чадаагүй улс орнуудын байр суурийг өөрчилж чадаагүй. Энэ системийн орнуудын гол дутагдал нь их, бага гүрнүүдийн ялгаа ихэсч, эсрэгцэл /иерархи/ бий болсон. Өөрөөр хэлбэл ямар нэгэн үйлдэл сөрөг үйлдлийг төрүүлж, ямар нэгэн хүч сөрөг хүчийг бий болгодог гэсэн үг. Олон улсын тавцан дээр улс орнууд энэ зарчмыг баримталсаар байна. Мөн энэ зарчим дээр хүчний тэнцвэр тулгуурладаг.

XX зууны эхний хагаст реалист онолын эцэг гэгддэг Америкийн улс төр судлаач Ханс Моргентау өөрийн бичсэн “Politics Among Nations” (1948) бүтээлдээ реалист онолын үндсэн дээр хүчний тэнцвэрийн онолыг тайлбарлажээ.

Тэрээр “Улс хоорондын бодлого нь эрх мэдлийн төлөөх тэмцэл бөгөөд хэн хүчтэй нь эрх мэдэлтэй төдийгүй алив аюулаас ангид эрх чөлөөтэй, дэвжин дээшлэх нөхцлөөр хангагдана” хэмээн бичжээ.² Үүнийг реалист онолын үүднээс тайлбарлавал олон улсын харилцааны зөрчлийг шийдвэрлэхэд эрх мэдэл бүхий бие даасан нэгж хамгийн чухал юм. Тиймээс аливаа улс тодорхой хэмжээний эрх мэдэлтэй байна гэдэг нь аюулгүй байдлаа бататган бэхжүүлэхэд хангалттай хүч боломжтой байхын нэр мөн. Энэ нь чухамдаа бусдад найдах биш өөрийн хүчинд тулгуурлах, зөвхөн өөрийн чадалд найдах үзлийг чухалчлахад хүргэжээ. Нэг үгээр хэлэхэд реалистууд олон улсын байгууллага ба хууль дүрмэнд хэт найдаж түүнд өөрийнхөө аюулгүй байдлыг даатгаж болохгүй гэсэн үзлийг баримталснаар өөрийн хүч чадлыг зузаатгах байнгын тэмүүлэлтэй болжээ. Үүнээс үүдэн зэвсэглэлээр хөөцөлдөх гинжин урвалд өөрийн эрхгүй татагдан орж байлаа. Ийм нөхцөлд олон улсын тогтвортой байдлыг хангах гол арга нь хүчний тэнцвэрийг /Balance of Power/ бий болгох явдал байв. Өөрөөр хэлбэл олон улсын тогтвортой байдал гэдэг нь хүчний тэнцвэрийг хадгалж чадсаны үр дүн болж байв.

Дэлхийн II дайны үеийн олон улсын харилцаан дахь хүчирхийлэл, түүний дараахь хоёр туйлт дайсагнасан харилцаа, цөмийн зэвсэглэл, хүйтэн дайны үеийн хурцадмал байдлууд нь олон улсын харилцааны реалист онолын үзэл баримтлалыг улам лавшруулж байлаа.

² Hans Morgenthau. “Politics Among Nations”, *The struggle for Power and Peace*. N.Y. 1965(4th ed) pp.13-14

Гэвч 1970-аад оны эхээр дэлхийн улс төрийн байдалд зарим өөрчлөлт ажиглагдав. Хурцадмал байдлын хажуугаар намжмал байдлын уур амьсгал (тухайлбал хамтран зөвлөх, зөвшилцөх, зэвсэг хорогдуулах зэрэг) Европ дахинд бий болж эхэлжээ. Үүний зэрэгцээ олон улсын институтуудын үүрэг нэмэгдэв. Ялангуяа Америкийн гадаад бодлогын стратегид зарим өөрчлөлт гарч дэлхий коммунизмын давшилтыг “тогтоон барих” бодлого нь (Энэтхэг-Хятадын хойгт) бүтэлгүйтсэнтэй холбогдон олон улсын бодит амьдралд илүү нийцсэн реалист онолыг шүүмжлэгчид буюу неореалистууд гарч ирсэн түүхтэй. Эхэн үеийн реалистууд Nation-State-ийг олон улсын харилцаанд гол оролцогчийн нь хувьд ихээхэн анхаарч түүний үүрэг, зорилгодоо хүрэх арга замыг тодорхойлоход чиглэж байсан бол неореалистууд дэлхийн бодлогыг олон улсын харилцааны системийх нь хувьд тогтолцоо талаас нь онцлон анхаарч үзэл бодлоо үндэслэх болжээ.

Тэд үзэхдээ дэлхий ертөнцөд нэгдсэн удирдлага бий болж төлөвшөөгүй, олон улсын эрх бүрэн үйлчилж чадахгүй байгаа, мөн Nation-State бүрийн хүч бололцоо харилцан адилгүй зэрэг олон улсын харилцааны өнөөгийн онцлог шинж улс орон бүрийн гадаад бодлогын шийдвэрт хүчтэй нөлөөлж байдгийг онцлон тэмдэглэж байна.³ Тийм учраас Nation-state-ийн бодлого хэрхэн яаж хэрэгжих бололцоо нь олон улсын системээс ихээхэн хамааралтайг анхаарах болжээ.

Гэхдээ неореалистууд мөн л хүч чадлын (Power) хүчин зүйлийг чухалчлан үздэг бөгөөд олон улсын тогтвортой байдлын үе дэх хүчний тэнцвэрийн тухай үзэл бодол чухал байр суурьтай ажээ.

Эдүгээ хүйтэн дайн төгсч, мэдээллийн хувьсгал гүнзгийрч, дэлхий ертөнцийн харилцан хамаарал ихсэх явцтай зэрэгцэн гадаад бодлого, олон улсын харилцаанд хамааралтай зарим ойлголт өөрчлөгдөж байна.

Юуны өмнө хүчирхэг улс гэдгийн хэмжүүрийг цэргийн гэхээсээ эдийн засаг, дэвшилт шинэ технологитой холбон ойлгох боллоо. Улс орон бүр хөгжлийн асуудалд илүү анхаарч аюулгүй байдлын агуулга шинж чанар улам баяжин өөрчлөгдөж байна. Хүчний тэнцвэр гэхээсээ ашиг сонирхлын тэнцвэр дээр үндэслэсэн гадаад бодлогыг хэрэгжүүлэх болов.

³ С.Дашзэвэг. “Олон улс судлал”. Олон улсын харилцааны реалист онол ба үндэсний аюулгүй байдал: хувьсгал өөрчлөлт. УБ хот. №1. 2002 он. 108-109-р тал

Энэ бүхнээс үзвэл олон улсын системийн болон дэлхийн бодлогын мөн чанар нь хүч чадал хийгээд эрх мэдлийн төлөөх өрсөлдөөн мөн мэт боловч нөгөө талд нь оршин тогтнох, өөрийгөө авран хамгаалахын төлөөх хамтын ажиллагаа бас мөн юм.

Орчин үед иймэрхүү хамтын хүчээр шийдэх олон чухал асуудал босон ирж улс орнууд бие биенээсээ улам бүр хамааралтай болсон нь өрсөлдөөнийг үгүй болгохгүй ч гэсэн эвсэлдээнийг чухалчлах хүн төрөлхтний сэтгэлгээг бий болгож байна. Дэлхийн бодлого, олон улсын харилцааны систем энэ чинээгээр өөрчлөгдөн хувирч буй хэдий ч хүчний тухай үзэл баримтлалд түшиглэсэн реалист онол шинэчлэгдэн өөрчлөгдөнө үү гэхээс хэзээ ч устаж үгүй болохгүй. Учир нь аливаа шинэ зүйл хуучныхаа суурин дээр үүсэн бий болж шинэчлэгдэн өөрчлөгддөг жамтай билээ.

ЗХА-ийн улс төрийн хүчний тэнцвэрийн асуудал

Ази, Номхон далайн бүс нутаг газар зүйн байршил, эзлэх хэмжээ, хүн амын төвлөрлөөрөө хамгийн том, ашигтайд тооцогдох, АНД-н дэд бүс нутгуудийн нэг болох Зүүн хойд Азийн бүс нутгийг өнөөдөр дэлхий нийтээр анхааран сонирхох боллоо. Зүүн хойд Азийн бүс нутагт Япон, БНХАУ, БНСУ, БНАСАУ, ОХУ, Монгол зэрэг улс багтах ба Номхон далайн хойт хэсэгт оршдог гэсэн утгаараа зарим орныг (АНУ, Канад) хамардаг бөгөөд эдгээр улс орон хөгжлийн түвшин, нийгмийн байгуулал, түүх соёлын уламжлалаараа хоорондоо асар их ялгаатай, харилцан адилгүй. Гэсэн хэдий ч газар зүйн хувьд хөршилсөн, харилцан хамаарал ихтэй, стратегийн чухал ач холбогдолтой бүс нутаг юм.

Эл бүс нутаг дахь Их гүрнүүдийн ашиг сонирхлыг ганц талаас нь авч үзэх нь учир дутагдалтай бөлгөө. Нэг нь улс төр, эдийн засаг, худалдааны ашиг сонирхолд голлон анхаарч байхад нөгөө нь эдийн засгаас гадна аюулгүй байдал, хүчний тэнцвэрт аль алинд нь нөлөөтэй байх, нөгөө нэг нь ЗХА-д нөлөөний хүрээгээ тэлэхийн сацуу бүхий л асуудлаар бүс нутгийн хэрэг явдалд голлон оролцох сонирхол нь давамгайлж байх зэрэг харилцан адилгүй, бүх талын ашиг сонирхлыг татсан бүс нутаг билээ. Ази, Номхон далайн бүс нутгийн хэмжээнд авч үзвэл АНУ, БНХАУ, ОХУ, Япон бүгд л өөр өөрсдийн түүхэн ашиг

сонирхолтой, өөр хоорондын нөлөөний хүрээгээ тэлэх эрмэлзэлтэй, нэг нь нөгөөгийнхөө нөлөөг хүчтэй болохоос ихээхэн сэрэмжилдэг нь тодорхой байна.⁴

Аюулгүй байдлын нэг гол субъект хүчний тэнцвэрийн асуудал нь олон улсын харилцааны судлагдах зүйл төдийгүй бүх бүс нутаг, олон хүчнүүдийг хамарсан ойлголт. Одоогийн байдлаар хамгийн хурцаар тавигдаж, сонирхол татаж буй асуудал бол орчин үеийн ЗХА-ийн бүс нутаг дахь хүчний тэнцвэрт харьцааны тухай ойлголт юм.

ЗХА-ийн бүс нутгийн хувьд хүчний тэнцвэрийн асуудал нь нэг талаар бүс нутгийн орнуудын геополитикийн ашиг сонирхлын илэрхийлэл төдийгүй улс орнуудын хоорондын харилцааг тодорхойлогч хүчин зүйл болдог.

Хүчний тэнцвэрийн тогтолцооны хүрээнд улс бүр өөрийн ашиг сонирхлынхоо хэрэгжилтийг ханган, холбоотнуудаа байнга өөрчлөн холбооны бүтэц, улс хоорондын харилцааны шинж чанарыг өөрчлөхөөс зайлсхийж иржээ. Хүчний тэнцвэрийн улс төрийн бодлогын сонгодог жишээ бол олон улсын харилцаанд хөндлөнгийн шүүгчийн үүргийг гүйцэтгэхийг оролдож байсан 19-р зууны Их Британийн бодлого юм.⁵

ЗХА-ийн бүс нутаг дахь хүчний тэнцвэр гэдэг ойлголтыг чухам аль талаас авч үзэх нь туйлын чухал. Жишээлбэл К.С.Гаджиев “Введение в геополитику” номондоо ерөнхийлөгч А.Никсоны төрийн нарийн бичгийн дарга асан, АНУ-ын томоохон улс төр судлаач Х.Киссинжерийн хүчний тэнцвэрийн онолыг тусгаж өгсөн байдаг. Тэнд хүчний тэнцвэрт харьцааг хадгалах 5 орныг цохон дурьдсан байдаг. Үүнд АНУ, БНХАУ, ОХУ, Япон, Баруун Европ хэмээн тодорхойлсноос 4 нь энэ бүс нутагт оршиж буй нь ямар чухал бүс нутаг болохыг гэрчилж байгаа хэрэг.

Энэ нь цэрэг стратеги, цөмийн зэвсэг, бүс нутаг дахь хөрөнгө оруулалт зэрэг олон хүчин зүйлээс хамаарна. Миний бодлоор энэ бүс нутаг дахь хүчний тэнцвэрийн асуудал АНУ-Хятадын худалдаа, эдийн засгийн харилцаа, зах зээлийн хүрээнд хурц илрэн гарч байна гэж бодож байна. Жишээ нь дэлхийн их гүрэн АНУ-тай эдийн засгийн үзүүлэлт, экспорт импортын хэмжээ, нийт худалдаа, бараа эргэлтийн дүнгээрээ ирээдүйд өрсөлдөж чадах, Японы дараа орох улс бол

⁴ Д.Цолмон, “ЗХА-ийн бүс нутаг дахь АНУ-ын стратегийн бодлогыг өөрчлөлт, хувьсал өөрчлөлт”
УБ 2003 он, 86-р тал

⁵ К.С.Гаджиев, “Введение в геополитику”. Москва. 1998 он. 126-р тал

БНХАУ билээ. XXI зуун Хятадын зуун болно гэж эрдэмтэн судлаачдын ярьж буй нь зөвхөн таамаглал төдий зүйл бишээ. 2002 онд АНУ, Хятадыг дэлхийн худалдааны байгууллагад элсэхэд элдэв хориг саад тавьж, эргэлзэж тээнэгэлзэж байсан нь хүний эрх, ардчиллынх нь түвшинтэй холбоотой авч энэ нь татгалзал төдий зүйл хараахан биш юм. Үүний цаад санаа нь Ази, Номхон далай, тэр дундаа их гүрнүүдийн анхаарлыг сүүлийн үед асар их татах болсон ЗХА-ийн энэ бүс нутагт өөрийн жин нөлөөг, тодорхой хэлбэл цэрэг стратеги, эдийн засгийн орон зайг алдах хүсэл АНУ-д байхгүй. Тийм ч учраас БНХАУ-ыг ДХБ-д элссэнийх нь дараа нь ч гэсэн тухайлбал, Хятадын зах зээлийг эзэлсэн дэлхийн нэртэй брэнд компаниудын бараа, бүтээгдэхүүнийг дуурайж үйлдвэрлэсэн тэр их хямд төсөр, дуураймал бараа, бүтээгдэхүүнд эдийн засгийн хориг хэмжээ тавьснаар АНУ-ын хувьд дуураймал бүтээгдэхүүнийг дэлхийн зах зээлээс шахах нэг сайн талтай, 2-рт АНД, ЗХА-ийн бүс нутагт жин нөлөө, эдийн засаг, худалдааныхаа өргөн боломж, 3-дагч түншүүдээ алдахгүй байхад нэн чухал ач холбогдолтой хэрэг болсон. Харин Хятадын хувьд энэ нь нэг талаас ДХБ-д элссэнээр дэлхийн тавцанд нэр хүнд нь өсөх, 2-рт худалдааны хөнгөлөлтүүдийг эдлэх зүйрлэшгүй сайхан боломж гарч ирсэн бол нөгөө талаар Хятадын эдийн засгийг хөл дээр босгосон, зах зээлийн 80 хувийг эзэлсэн тэр их хэмжээний хямд төсөр, хуурамч бараа бүтээгдэхүүнийг хааш нь гаргах, хуурамч үйлдвэрлэлийг таслан зогсоох тухай ДХБ-аас тавьсан хатуу шаардлагыг бүх улсын хэмжээнд хэрэгжүүлэх нь давшгүй даваа, толгойны өвчин болсон гэхэд хилсдэхгүй билээ. Тэр их хямд төсөр, хуурамч барааг (цаашид ч гэсэн) гадагшлуулах томоохон зах зээл нь хил залгаа оршиж буй ОХУ, Монголын зах зээл мөн. Энэ утгаар Хятадын хуурамч үйлдвэрлэлийн муу үр дагаварын хар сүүдэр нь Монголыг дайрч байна гэхэд хилсдэхгүй. Учир нь манай Монголын зах зээлд хүч түрэн орж ирэх асар их бараа, бүтээгдэхүүн нь хямд төсөр талаараа манай ард түмний ахуй байдлыг аргацаах талтай ч сүүлийн үед Монголд үйлдвэрлэв гэсэн шошготой барааг БНХАУ, Монгол улсын нэрийн өмнөөс дэлхийн зах зээлд гаргах болсон явдал нь Монголын үйлдвэрлэлийн нэр хүндэд муугаар нөлөөлөөд зогсохгүй, цаашилбал ДХБ-аас Монгол улсын бараа бүтээгдэхүүнд тавиулах хоригоор “шагнуулах” талтай. Иймээс Монгол улсын эдийн засаг БНХАУ-ын үйлдвэрлэсэн хуурамч барааны муу нэр алдрыг зүүж, Хятад улс ард нь цэвэр үлдэж нэрээ хамгаалах

талтай. Орос бол эдийн засаг нь уналтанд орсон, дорой гэж хэдий яригдаж буй ч газар нутаг, хүн амын тоо, шинжлэх ухаан, техникийн дэвшил, эдийн засаг нь сэргэж буй их гүрэн гэсэн утгаараа ч гэсэн манайхыг бодвол харьцангуй эрсдэлд бага өртөх боломжтой гэдгийг давхар хэлмээр санагдлаа.

Нөгөө талаар АНУ дангаараа БНХАУ-ын бараа эргэлт, экспорт, импортын 30 орчим хувийг эзэлдгийн хувьд БНХАУ дангаараа АНУ-ын бараа эргэлт, экспорт, импортын 20 хувийг эзэлдэг нь шууд пропорциональ хамааралтай тул аль аль нь энэ их ашиг орлогоо алдах алхам яаравчлан хийхгүй нь ойлгомжтой.

Сүүлийн үед Хятадыг будаагаараа дэлхийд тэргүүлж дэлхийн будааны нөөцний ихэнх хувийг хангах чадвартай боллоо гэгдэж буй ч энэ шийдвэрийг АНУ тийм хурдан зөвшөөрч хүлээн авахгүй нь лав. Ингэсэн тохиолдолд БНХАУ-ын дэлхийн зах зээлд Ази, Номхон далай руу гарах гарц нь Тайвань, цаашилбал Вьетнам болох боломжтой. Тэгвэл өнөөдрийн Тайваний тусгаар тогтнолыг Хятад хэзээ ч зөвшөөрөхгүй. АНУ “нэг Хятад, хоёр систем” гэдэг номлолыг хүлээн зөвшөөрлөө ч гэсэн Тайваний аюулгүй байдал, газар нутгийн бүрэн бүтэн байдал, тусгаар тогтнолын асуудал хөндөгдвөл холбоотны ёсоор энэ хэрэгт оролцож Тайваний түншээр цэрэглэн хөдлөх нь мэдээж. Үүний дүнд хүчний тэнцвэрт харьцааг хангах хоёр их гүрний хоорондох шаврын хаалтаар Тайвань тодорч дунд нь үрэгдэх эсэх нь наад захын асуудал болон хувирна. Энэ бүхэн бол ЗХА-ийн бүс нутагт гарч буй, ирээдүйд гарах эдийн засгийн асуудлаар илрэх хүчний тэнцвэрийн нэгээхэн бэрхшээл юм. Бид ийм байдлаар дүрсэлж байхад орчин үеийн олон улсын харилцааны шинэ хандлага нөхцөлд БНХАУ, Монголыг анхааран үзэхдээ Америкийн аюул занал Монголоор дамжин Хятадад нүүрлэнэ хэмээн сэрэмжилдэг талтай. Үүнтэй уялдаад БНХАУ Монголтой харилцаагаа бэхжүүлэн Монголын гадаад бодлогыг Америк руу хэт хэлбийхээс сэргийлэх нь Хятад, Оросын аль алиных нь нийтлэг ашиг сонирхолд нийцнэ. Учир нь Монгол нь аль хэдийнээс Хятад, Америк, Орос гурван их гүрний гурвалжилсан харилцааны нэг цэг болсон тул Монгол тэнцвэрийн цэг дээр байх үед манай улсын хувьд ашиг олох хамгийн таатай нөхцөл болж байна.

Харин цэрэг зэвсэг, аюулгүй байдлын хувьд илрэх хүчний тэнцвэрт харьцаа нь арай өөрөөр тусах болов уу. Дэлхийн хэмжээнд цэрэг, зэвсгийн хэмжээ, техник технологийн шинэ дэвшил, байлдааны зэвсэг техникийг турших

байдлаараа АНУ-ыг давах өөр гүрэн үгүй. БНХАУ зэвсгийн техник технологиороо АНУ-д хүрэхгүй ч цэрэг армийн бие бүрэлдэхүүний хувьд ямар ч улсыг дагуулахгүй. Батлан хамгаалах салбарт зэр зэвсэг, техник технологи чухал ч хүн амын тоо, газар нутгийн хэмжээгээрээ их гүрний статустай улс юм. БНХАУ-аас АНУ далдхан сэрэмжилж байдаг нь одоогийн ерөнхийлөгч Ж.Бушийн “Хятад бол манай стратегийн гол түнш бус стратегийн гол өрсөлдөгч”⁶ хэмээсэн тодорхойлолттой дүйцэх мэт санагдана. Дээр нь АНУ-ын цэргийн томоохон баазууд Япон, БНСУ-д байрлаж байгаа нь бүс нутгийн аюулгүй байдлыг өөрийн хараа хяналтанд авч, аль нэг холбоотон руу нь довтолсон тохиолдолд гэрээний дагуу тухайн улсын аюулгүй байдлыг хангах; хамгаалах, хүчний тэнцвэрт харьцааг барих үүднээс тэмцэлд нэгдэх нь ойлгомжтой. Ийм өргөн хүрээг хамрах асуудал (Солонгосын хойгийн байдлыг эс тооцвол) ноцтой л биш бол гарах магадлал харьцангуй бага. Энэ утгаараа АНУ, Ази, Номхон далайн салбар болох ЗХА-ийн бүс нутагт өөрийн жин нөлөө, цэрэг, зэвсгийн хүчний тэнцвэрт харьцааг хадгалж байх стратегийн ашиг сонирхолтой юм.

Дүгнэлт

Аливаа бүс нутагт хүчний тэнцвэр тухайн бүс нутаг дахь улс орнуудын улс төр, эдийн засаг, цэрэг-стратегийн аюулгүй байдлаас шалтгаалан заавал оршин тогтнож байдаг. Хүчний тэнцвэрийн асуудал нь олон улсын харилцааны судлагдах зүйл төдийгүй бүх бүс нутаг, олон хүчнүүдийг хамарсан ойлголт.

Ер нь хүчний тэнцвэрийн онолыг цэрэг стратеги, батлан хамгаалах, аюулгүй байдал, энхтайван, эдийн засгийн тэнцвэржилтийн үүднээс тайлбарлах хэрэгтэй.

Түүхээс өвлөгдсөн олон ужиг асуудал олонтой, газар нутгийн маргаан намжаагүй, хуваагдмал үндэстнүүдтэй, бие биендээ үл итгэх явдал байсаар байгаа АНД, ЗХА-ийн бүсэд АНУ, Япон, Орос, Хятад зэрэг дэлхийн том гүрнүүдийн эрх ашиг харилцан солбилцож байдгийг бид мэднэ. Одоогийн байдлаар хамгийн хурцаар тавигдаж, сонирхол татаж буй асуудал бол орчин үеийн ЗХА-ийн бүс нутаг дахь хүчний тэнцвэрт харьцааны тухай ойлголт юм.

⁶ George Bush. “The inaugural address”, Washington.D.C, 2001

ЗХА нь XIX зуунаас хойш маргаантайд тооцогдож буй АНУ, ОХУ, БНХАУ, Япон зэрэг дэлхийн дөрвөн хүчирхэг орнуудын сонирхлыг зүй ёсоор татаж буй бүс нутаг бөгөөд эдгээр хүчний тэнцвэрийг илэрхийлэгч эдгээр гүрнүүдийн хоорондын харилцаа нь тухайн бүс нутаг дахь нөхцөл байдлаар тодорхойлогдож байдаг. ЗХА-ийн бүс нутгийн хувьд хүчний тэнцвэрийн асуудал нь нэг талаар үндэсний эрх ашгийн илэрхийлэл болдог бол нөгөө талаар бүлэг улсуудын хоорондын харилцааны илэрхийлэл болдог байна.

Энэ бүс нутаг дахь хүчний тэнцвэрийн асуудал тухайн бүс нутагт оршдог улс орнуудын үндэсний эрх ашигтай зүй ёсоор холбогдох бөгөөд уг бүс нутгийн хүчний тэнцвэрт харьцаа нь одоогийн дэлхий дахин, бүс нутгийн хооронд гарч буй өөрчлөлт, зөрчилдөөнөөс шалтгаалан хүчнүүдийн ашиг сонирхлын тэнцвэрт харьцаа болон хүрээгээ тэлэх магадлал өндөр байгаа юм. Үүнээс үзэхэд хүчний тэнцвэрийн тухай ойлголт нь цаг үеэ даган хүрээгээ тэлэн оршино уу гэхээс хэзээ ч устаж үгүй болохгүйг цохон тэмдэглэх хэрэгтэй.

Монгол улсын тухайд бүс нутаг дахь нөлөө бүхий улс гүрнүүдийн ашиг сонирхлын ойртолт, зөрчил, хүчний тэнцвэрийг мэдэрч улмаар гадаад улс төр, эдийн засгийн үйл ажиллагаагаа харгалзан үзэж ухаалаг дипломат ажиллагаа явуулах шаардлага зүй ёсоор урган гарч байна. Эцэст нь хэлэхэд ЗХА-д хүчний тэнцвэр хэмээх өргөн ойлголт нь аюулгүй байдлыг хангах, бүх талын ашиг сонирхлыг татсан хүчин зүйл бөгөөд одоогоор ашиг сонирхол дээр тулгуурласан хүчний тэнцвэр болж хувираад байна.

Ашигласан материал

1. Монгол хэлээр ашигласан эх сурвалжууд:

1. "Монгол улсын ҮАБ-ын үзэл баримтлал" УБ хот, 1994 он
2. "Монгол улсын үндэсний аюулгүй байдлын тухай хууль" УБ хот, 2001 он
3. Ном, сэтгүүл, сонин хэвлэл
4. Н.Алтанцэцэг. "Зүүн хойд Азийн төлөв байдал ба Монгол Улс", УБ, 2003 он
5. "Алтан Аргамж" сэтгүүл, МУИС-ийн ОУХС, 2001 '4, Vol.4(171)
6. Б.Балдоо. "Монгол улсын гадаад харилцаа", XX зууны эхэн ба төгсгөл үе, 2003 он, УБ хот
7. Батлан хамгаалахын цагаан ном, 1998, 2001 он, УБ хот
8. Ц.Батбаяр. "Ази, Номхон далайн хамтын нийгэмлэгийн дүр төлөв, түүнд Монголын эзлэх байр суурийн асуудал", "Дорно-Өрнө сэтгүүл", 1994 '2
9. Ж.Баясах. "Зүүн хойд Ази хийгээд Монгол Улс", "Стратеги судлал" сэтгүүл, 1998 '2, 1-5-р тал
10. Д.Баярхүү "Евразийн геополитик ба олон улсын харилцаа одоо ба ирээдүй", УБ, 2002 он

11. Р.Болд. "Монголын аюулгүй байдлын орчин, батлан хамгаалах бодлогын зарим асуудал", УБ, 1996
12. Ж.Бор. "Бүс нутгийн аюулгүй байдал ба Монгол улсын үндэсний аюулгүй байдал", "Гурав дахь хөрий", УБ, 2002
13. Ж.Бор. "ЗХА-ийн аюулгүй байдлын систем ба Монгол улс", "Стратеги судлал" сэтгүүл, УБ, 1999 '2
14. С.Галсанжамц. "Ази, Номхон далайн аюулгүй байдлын хамтын ажиллагааны зөвлөл", "Стратеги судлал" сэтгүүл, УБ, 1998 '1
15. Ц.Гомбосүрэн. "Олон тулгуурт гадаад бодлого-үндэсний аюулгүй байдлын чухал хүчин зүйл", "Стратеги судлал" сэтгүүл, УБ, 1998 '1
16. Б.Лхамсүрэн. "Монголын гадаад орчин, төрийн тусгаар тогтнол", УБ, 1996
17. "Монгол улсын аюулгүй байдал", Монгол, Орос судлаачдын үзэл бодол
18. "Монголын аюулгүй байдлын орчин", Стратеги судалгааны хүрээлэн, УБ, 1995
19. "Монцамз", 2003.11.13, УБ хот
20. Ч.Найдансүрэн, Д.Содномгомбо. "Монгол улсын үндэсний аюулгүй байдал, түүнийг хангах зарим асуудал"
21. А.Нямдолжин. "ОХУ-ын Ази, Номхон далайн бүс нутагт явуулж буй гадаад бодлого" УБ, 1999 он
22. С.Отгонбаатар. "Зүүн хойд Азийн бүс нутгийн интеграцийн асуудал", "Олон улсын харилцаа сэтгүүл", УБ, 2002 '2
23. "Олон улс судлал" сэтгүүл, УБ, 1999 '1(11); 2001(1); 2002 '2, Vol.196(6); 2000(2); 2002(2-3)
24. Профессор Майкл Хандел. "Олон улсын систем дэх жижиг орнууд"
25. Д.Цолмон. "Даяаршил ба бага буурай орнуудын аюулгүй байдлын зарим асуудал", "Стратеги судлал" сэтгүүл, УБ, 2002 '2
26. Д.Цолмон. "ЗХА-ийн бүс нутаг дахь АНУ-ын стратегийн бодлогыг өөрчлөлт, хувьсал өөрчлөлт", УБ 2003 он
27. "Монгол улс ба Зүүн хойд Ази" УБ, 2002 он. ШИВА, ОУСХ

II. Англи хэлээр ашигласан эх сурвалжууд:

1. Alvin Magid, Richard W.Mansbach⁶ "Mongolian Security in the XXI century: in quest of friends and partners. Not Allies", magazine of Strategic studies, 1999 '2
2. "Asia Perspectives". Vol. 5(2), spring 2003
3. D.Bayarkhuu. "New Central Asia: New Paradigm, New Paradox and Counter Balance", Ulaanbaatar. 2001
4. Ts.Batbayar. "Mongolia's foreign policy in the 1990-s: New Identity and New Challenges", Ulaanbaatar. 2003
5. Colin L.Powell. "Remarks at Asia Society Annual Dinner", June 10, 2002
6. George Bush. "The inaugural address", Washington.D.C, 2001
7. Japan emphasizes its membership in international regimes such as the NPT, IAEA, Nuclear Suppliers Group, CTBT, and the MTCR.
8. Harold Karan Jacobson. "America's foreign policy", NY, 1995
9. Henry Kissinger. "Does America need a foreign policy"?
10. Howard W. French. "Nuclear Arms Taboo is Challenged in Japan" The New York Times, June 9, 2002
11. Kim Hakjoon. "Korea's relations with her neighbours in a changing world", Seoul, 1998
12. "Pacific Focus" Inha Journal of International Studies, Vol.XV, '2, fall 2000, 2001, 2002, 2003

13. Stephen E. Noerper. "Mongolia, North Korea and the new security architecture in Northeast Asia", *World Affairs*, 2002 '2

14. U.S. Security Strategy for the East Asia-Pacific Region (Washington, D.C. Department of Defence, 1998)

III. Орос хэлээр ашигласан эх сурвалжууд:

1. З.Бжезинский. "Великая шахматная доска", Москва, 1997 г.
2. К.С.Гаджиев. "Введение в геополитику", Москва, 1998 г.
3. Гельбрас В.Г. Азиатско-Тихоокеанский Регион: Проблемы экономической безопасности России, Москва, 1998 г.
4. А.С.Нартов. "Геополитика", Москва, 1998 г.

IV. Интернет, веб сайтыуд:

1. <http://www.state.gov.com>
2. <http://www.foreignpolicy.com>
3. <http://www.balanceofpower.com>
4. <http://www.nationalinterests.com>
5. <http://www.cnn.com>
6. <http://www.reuters.com>
7. <http://www.bbc.com>
8. <http://www.Washingtonpost.com>
9. <http://www.New-Yorktimes.com>
10. <http://www.USAToday.com>
11. <http://www.Pravda.ru.com>
12. <http://www.Erina.org.jp>
13. <http://www.six-party talk.com>